

Шинжааны тува хэлний гийгүүлэгч авианы тухай судалгааны тойм

ЦЭЛГЭР*

БНХАУ-ын ӨМӨЗО, Хөх хот,
Өвөр Монголын Их сургуулийн Монгол Улс судлалын хүрээлэн

Submitted: September 25, 2025 | **Accepted:** November 30, 2025

Хураангуй: Тува хэл нь Бүгд Найрамдах Хятад Ард Улс, Монгол Улс, Оросын Холбооны Улсын хил дамнан хэрэглэгддэг хэлний нэг юм. Энэхүү өгүүлэлд голчлон Хятад улсын Шинжаан дахь тува хэлний гийгүүлэгч авианы судалгааны өнөөгийн байдлыг тоймлон дүгнэж, уг хүрээнд хийгдсэн эрдэм шинжилгээний ажлуудыг тогтолцоотойгоор эмхэтгэн Шинжааны Тува хэлний гийгүүлэгч авианы онцлог, ангилал түүний төрөл зүйлийн ялгаа, хэрэглэж буй судалгааны арга зүйг хамруулан авч үзэв. Мөн цаашид уг хэлний бусад нутгийн аялгуутай харьцуулсан судалгааг гүнзгийрүүлэх шаардлага буйг онцолсон байна. Үүнээс гадна судалгааны өнөөгийн ололт, дутагдал, цаашид өргөжүүлэх боломжит чиглэлийг тодорхойлон, Шинжааны тува хэлний авиа зүйн судалгаанд онол, арга зүйн суурь лавлагаа болгохыг зорьжээ.

Түлхүүр үг: Шинжааны тува хэл, гийгүүлэгч авиа, авиа зүйн судалгаа, судалгааны тойм

An Overview of Research on Consonant Phonemes in the Xinjiang Tuva Language

TSELGER

Center for Studies of Mongolia, Inner Mongolia University,

Abstract: *The Tuvan language is a rare and relatively under-researched language spoken across three countries-the People's Republic of China, Mongolia, and the Russian Federation. This paper provides a comprehensive review of the current state of research on the consonantal phonology of Tuvan as spoken in Xinjiang, China. It systematically summarizes the scholarly works conducted in this field, focusing on the articulatory and phonological characteristics of Tuvan consonants, their classifications, and the methodological approaches employed in previous studies. The paper further highlights the need for more in-depth comparative research on dialectal variation among Tuvan-speaking regions. In addition, it identifies key achievements and existing gaps in the current body of research and proposes potential directions for future study. Overall, this work aims to offer both theoretical and methodological references for further phonetic and phonological investigations of the Tuvan language in Xinjiang.*

Keywords: *Xinjiang Tuvan, consonants, phonological research, research overview*

1. Удиртгал

Тувачууд нь Ази, Европ хоёр тивийг дамнан оршин амьдарч ирсэн, өвөрмөц хэл, соёл бүхий эртний угсаатны нэг юм. Тэдний уугуул нутаг нь гол төлөв Оросын Холбооны Улсын Бүгд Найрамдах Тува Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Шинжаан Уйгарын өөртөө засах орон, мөн Монгол Улсын баруун хэсгийг хамардаг бөгөөд улс дамнасан онцлог бүхий нэгэн угсаатны бүлэг юм.

1.1. Оросын Холбооны Улсын нутаг дэвсгэр дэх тувачууд Сибирийн өмнөд хэсгийн Саяны нуруу ба Тагнын уулын хооронд орших уудам нутагт амьдардаг, ойролцоогоор гучин мянга гаруй хүн амтай. Харин Хятад Улсын Шинжааны тувачууд гол төлөв Алтай аймгийн Ханас нуурын орчмоор суурьшсан бөгөөд нийт гурван мянга орчим хүн амтай байна. Гэсэн хэдий ч хүн амын цөөн тоо болон түүхэн онцлог зэрэг шалтгаанаас үүдэн XX зууны эхэн үеийн Хятад Улсын үндэстний бүртгэл, ангиллын явцад Шинжааны тувачуудыг монгол үндэстний нэгэн хэсэг хэмээн үзэж, монгол үндэстэнд хамааруулан бүртгэж байжээ. Монгол Улсын хил дотор орших тувачууд нь тус улсын түрэг хэлтэн угсаатны бүлэгт багтах бөгөөд гол төлөв Увс аймгийн тагнын урианхайчууд, мөн Баян-Өлгий аймгийн алтайн урианхайчуудын дунд оршин сууж байна. Монгол Улсад гучин мянга гаруй тува оршин суудаг бөгөөд дэлхий даяар гучин

зургаан мянга орчим тооны тувачууд байна. Хятад Улсын тувачууд ихэвчлэн Алтайн уулсын өмнөд бэлд, Шинжааны Уйгарын өөртөө засах орны хойд хэсгийн Или, Хасагийн өөртөө засах жөүгийн нутагт төвлөрөн амьдардаг. Тухайлбал, Алтай аймгийн Бууржин шяний Хом, Ханас Монгол үндэстний сумын Хом тосгон, Ханас тосгон, Хав шяний Цагаан хав тосгон, мөн Алтай хот, Аллаг тосгон, Хөхтохой шяний Темег сум, Чингэл шянь, Бууралтохой шянь зэрэг газруудад тархан нутагшжээ (Бат-Очир, 2013: 6).

1.2. Тэд өөрсдийгөө “дэва” (dewa) буюу “дэба” (deba) хэмээн нэрлэдэг бол, хөрш Хасагууд тэднийг “гөк мончок” (gøkh monʃhov) эсвэл “урианхай” (oraŋxaj) гэж нэрлэдэг байна. “Тува” хэмээх нэрийн үүсэл гарал нь Хятадын “图瓦” (Ту ва) гэх бичлэгтэй холбоотой гэж үздэг. Энэ нэрийн түүхэн үндсийг анх “Сүй улсын бичиг”, “Умардын түүх” зэрэг сурвалжид “都播” (Ду бо) буюу “都波” (Ду бо) хэлбэрээр тэмдэглэжээ¹. “Шинэ Тан улсын бичиг”-т “都波” (Дубо)², “Ляо улсын түүх”-д “嗚良改” (Вэнь лян гай), “嗚良罕” (Вэнь лян хань)³, харин “Юань улсын түүх”-д “秃巴思” (Ту ба сы), “秃巴” (Ту ба), “秃八” (Ту ба)⁴ гэсэн нэрээр тус тус тэмдэглэсэн ба Чин улсын үед Алтай орчмын тувачууд болон тухайн бүсийн Монголчуудыг хамтад нь “Алтайн урианхай”⁵ хэмээн нэрлэж байжээ. XX зууны турш Хятад хэлний судалгаанд “德瓦” (Дэ ва), “德巴” (Дэ ба), “秃巴” (Ту ба) зэрэг хэлбэрээр тэмдэглэж байснаа сүүлийн үед “图瓦” (Ту ва) гэж тогтжээ. Шинжааны тувачууд нь урт удаан хугацааны соёлын уламжлал, өвөрмөц аман болон бичгийн соёл, зан заншлаа өнөөг хүртэл хадгалсаар ирсэн онцгой угсаатны бүлэг юм. Гэсэн хэдий ч хүн амын хэт цөөн байдал, хэлний дам нөлөө зэрэг шалтгаанаас үүдэн тэдний хэрэглэж буй Шинжааны тува хэл нь өнөөдөр Хятад Улсын хэмжээнд мөхөх аюултай хэлний тоонд орсон байна.

2. Судалгааны арга зүй

Энэхүү өгүүлэлдээ БНХАУ-ын нутаг дэвсгэрт оршдог угсаатны бүлэг болох тувачуудын хэл аялгууг судалж ирсэн байдал болон тэдний хэлийг бүрдүүлж буй авиа, авиалбарын судалгааны талаар харьцуулан үзэж товчоолон бичих аргыг хэрэглэв.

1, 2, 4, 5 “Хятад Улсын түрэг төрлийн хэлний тойм байдал”, Хятад Улсын түрэг хэлний судлалын нийгэмлэг, 1983 он, 117-р тал.

3 Хан Рүлин “Тан улсын див”, “Нийгмийн шинжлэх ухааны байлдааны шугам” сэтгүүл, 1978 оны 3-р дугаар, 143-р тал.

3. Хятад Улс дахь судалгааны тойм

Хятад Улсын эрдэмтэн судлаачид Шинжааны Алтай орчмын тува хэлийг илрүүлэн судалж эхэлснээс хойш тус хэлний судалгаа аажмаар өрнөсөн бөгөөд Орос дахь тува хэлний судалгаатай харьцуулахад харьцангуй хожуу эхэлсэн гэж үздэг.

1956 онд БНХАУ-ын Шинжлэх Ухааны Академи болон Төвийн Үндэстний Дээд Сургуулийн харьяа “Хасаг хэлний ажлын дугуйлан”-ийн судалгааны баг Шинжааны Алтай аймагт хэл шинжлэлийн судалгаа хийх явцдаа тува хэлийг анх илрүүлж, холбогдох хэлний материалуудыг цуглуулсан байна. Энэхүү ажлыг ахалсан Гэн Шы мэй багш цуглуулсан баримт, материалуудыг эмхэтгэн тува хэлний талаарх анхны мэдээ, ажиглалтыг нийтэлж, тухайн үеийн хэл шинжлэлийн хүрээнийхний анхаарлыг татжээ.

1980 онд Өвөр Монголын Их Сургуулийн багш Чойжинжав оюутнуудын хамт Шинжааны Алтай аймгийн Алтай, Бууржин, Хав, Хөхтохой зэрэг шяньд судалгааны ажиглалт хийж, тухайн үед “Хөх мончог” хэмээн нэрлэгдэж байсан Тувачуудын хэлний байдалд дүн шинжилгээ хийжээ. Судалгааныхаа үр дүнд тэрбээр “Хөх мончог ба тэдний хэл - түрэг хэлээр ярьдаг монголчууд”, “Хөх мончог хэлний монгол зээл үгсийн тухай туршин өгүүлэх нь (I)”, “Хөх мончог хэл ба монгол хэлний эгшиг авианы харьцууллаар монгол хэлний авиа зүйн түүхийн зарим асуудлыг шинжлэх нь” зэрэг өгүүллүүдийг бичиж, тувачуудын хэл, соёл, аж амьдралын талаар нарийвчилсан судалгаа хийсэн байна.

1980-аад оны эхээр Хятад Улсын Нийгмийн Шинжлэх Ухааны Академийн Үндэстний судлалын газрын судлаач Сүн Жэнчүнь Шинжааны Алтай аймгийн Хав гол шяний Цагаан хав тосгонд хэлний шинжилгээ хийж, түүндээ тулгуурлан “Тува хэлний судлал” хэмээх сэдвээр магистрын зэрэг хамгаалсан байна. Улмаар 1984 онд дахин судалгаа хийж, “Тувачуудын давхардал хэлний тогтолцоо” бүтээлээрээ докторын зэрэг хамгаалжээ. Тэрээр “Тува хэлний тойм байдал”, “Манай улсын тува хэлний авианы системийн тухай анхны шинжилгээ”, “Шинжааны тувачуудын олон хэлт гэр бүлийн хэлний хэрэглээ” зэрэг өгүүлэл нийтэлж, тува хэлний авиа зүй, хэл зүй, хэлний хэрэглээний асуудлыг цогц байдлаар судалсан байна. Сүн Жэнчүнь -ийг Хятад дахь Шинжааны тува хэлийг системтэйгээр судалсан анхны эрдэмтэн гэж үздэг.

1990 онд Чэнь Зүнжэнь тэргүүтэй эрдэмтэд “Хятад Улсын түрэг хэлний үгсийн хураангуй” нэртэй бүтээлийг хэвлүүлсэн бөгөөд Сүн Жэнчүний цуглуулсан 4000 орчим тува үгийг эмхэтгэн багтаажээ. Чэнь Зүнжэнь “Хятад Улсын түрэг хэлний үгсийн сангийн тойм” нэртэй өгүүлэлдээ түрэг хэлний төрөл зүйл,

тархалт, үгийн бүтцийн онцлог, гарал үүсэл зэргийг тодорхойлж, номын хавсралтад тува хэлийг багтаасан найман төрлийн түрэг хэлний үг бүтээх дагаврыг жагсаасан байдаг.

1985 онд Шинжааны Уйгарын Өөртөө Засах Орны Үндэстний Хэрэг Эрхлэх Хороо, Нийгмийн Шинжлэх Ухааны Хүрээлэн, Шинжааны Их Сургууль болон бусад байгууллагууд хамтран Алтай аймгийн тувачуудын түүх, угсаа гарал, хэл, аж ахуй, шашин, зан заншлын талаар иж бүрэн судалгааны баг зохион байгуулжээ. Энэхүү ажлыг Чэн Шылян удирдан гүйцэтгэсэн бөгөөд тэрбээр “Алтайн тувачуудын хэлний тойм байдал”, “Алтайн тувачуудын хэлний тойм байдал (үргэлжлэл)” нэртэй хоёр өгүүлэл бичиж, тува хэлний авиа зүй, хэл зүй, үгсийн сангийн онцлогийг нарийвчлан тодорхойлсон байна.

1999 онд Хятад Улсын Нийгмийн Шинжлэх Ухааны Академийн эрдэмтэн У Хунвэй “Тува хэлний судлал” хэмээх бүтээлээ хэвлүүлсэн нь тус салбар дахь томоохон эрдэм шинжилгээний бүтээл болсон юм. Тэрбээр судалгаагаа Шинжааны тувачуудын хэлний талаарх анхан шатны ажиглалт, материалд тулгуурлан гүйцэтгэж, тува хэлний авиа зүй, үгийн сан, хэл зүй, өгүүлбэр зүйг цогцоор нь судалж, Тува хэлний түрэг хэлний аймаг дахь байр суурийг тодорхойлжээ. Мөн “Хятад Улсын тувачууд болон Оросын тувачуудын хэлний авиалбарын харьцуулсан судалгаа” зэрэг өгүүлэл нийтэлж, хоёр орны тува хэлний ялгаатай болон төстэй байдлыг тодруулсан байна.

Үүнээс гадна Төвийн Үндэстний Их Сургуулийн багш Чэн Шылян “Түрэг хэлний харьцуулсан хэл шинжлэл”, Майти Вим Шаитийн “Түрэг хэл шинжлэлийн удиртгал”, Литиф Түхүт нарын “Алтай хэл шинжлэлийн удиртгал” зэрэг бүтээлд Шинжааны тува хэлний гарал үүсэл, хэлний язгуур харьяалал, онцлогийг тус тус дурдсан байдаг.

Сүүлийн жилүүдэд тува хэлний судалгаа улам гүнзгийрч, олон эрдэм шинжилгээний өгүүлэл, магистр, докторын зэрэг хамгаалсан бүтээлүүд гарчээ. Тэдгээрийн дотроос дараах бүтээлүүдийг онцгойлон дурдаж болно. “Хос хэлний боловсролын зогсонги байдлаас соёлын хүрэлцэл ба хүлээлтийг ажиглах нь - мөхөх аюулд буй тува хэлний жишээгээр” (2010), “Тува хэл дэх монгол гаралтай зээл үгсийн судлал” (2010), “Тува хэл монгол хэлний нөлөөнд орсон байдал” (2010), “Тува хэлний монгол зээл үгийг хоршоо үгийн задлалтын аргаар ялган судалсан нь” (2010), “Тува хэл ба монгол хэлний харьцуулсан судлал” (2010), “Шинжааны Алтай аймгийн тува хэлний нэр үгийн нэрийдлийн хэлбэрийн харьцуулсан судалгаа” (2012), “Шинжааны тува хэлний хэрэглээний судалгаа” (2013), “Шинжааны Тувачуудын хэлний хэрэглээ ба хэлэнд хандах хандлагын судалгаа - Ханас тосгоны жишээгээр” (2016, англи хэлээр), “Тува хэл дэх хятад

гаралтай зээл үгсийн судлал” (2017), “Шинжааны тува хэлний /e/ эгшгийн дуудлагын дүн шинжилгээ” (2017), “Шинжааны тува хэлний үгийн эхний үеийн богино эгшгийн дууны авиа зүй” (2018), “Шинжааны тува хэлний үгийн хоёрдугаар үеийн богино эгшгийн дууны авиа зүй” (2019), “Акустик шинжилгээнд суурилсан Шинжааны тува хэлний эгшгийн тогтолцооны судалгаа” (2019) гэх мэт. Эдгээр бүтээл нь Хятад дахь тува хэлний судалгааг шинэ түвшинд гаргаж, тус хэлний авиа зүйн онцлог, хэл-соёлын нөлөөлөл, мөхөх аюулд буй хэлний хэрэглээний асуудал зэрэг сэдвийг гүнзгий авч үзсэнээрээ онцлог юм.

4. Шинжааны тува хэлний гийгүүлэгч авианы тухай судалгаа

Шинжааны тува хэлний гийгүүлэгч авианы судалгааг нарийвчлан задлан шинжилбэл, тува хэлний Хятадын судлаач Сун Жэн чүнь, Чэн Шы лян, У Хун вэй, Саранхуар зэрэг хүмүүсийн судалгааны бүтээлийг дурдах ёстой болдог. Тува хэлний гийгүүлэгчийн тухай дээрх судлаачдын үзэл санаа их төлөв нэгдэлтэй байдаг боловч зарим гийгүүлэгчийн тухайд тува хэлэнд байх эсэх, мөн гийгүүлэгчүүдийн өгүүлэх эрхтний байр ямар болох тухай асуудлаар санал зөрөлддөг.

1. Сун Жэн чүнь “Тува хэл ба тувачуудын олон хэлт гэр бүл” (Хятад Улсын Нийгмийн Шинжлэх Ухааны Хэвлэлийн Хороо, 2015 он)-д, тува хэлэнд нийт “p, b, m, w, s, z, t, d, n, r, l, ʃ, ɕ, ʒ, ʒ, k, g, ŋ, x, j” (зохиогчийн хэрэглэсэн галигаар гийгүүлэгч авиаг тэмдэглэв) зэрэг хорин гийгүүлэгч авиа бий гээд (2015: 9), тэдгээрийг өгүүлэх эрхтний байраар нь хоёр уруулын гийгүүлэгч (p, b, m, w), хэлний үзүүрийн өмнөх гийгүүлэгч (s, z), хэлний үзүүрийн дундах гийгүүлэгч (t, d, n, r, l), хэлний өмнөд этгээдийн гийгүүлэгч (ʃ, ɕ, ʒ, ʒ), хэлний өргөн талын дундуурх гийгүүлэгч (j), хэлний угийн гийгүүлэгч (k, g, ŋ, x) зэрэг зургаан төрөлд ангилан, өгүүлэх аргаар нь хамжих гийгүүлэгч (p, b, t, d, k, g), хамжин шүргэх гийгүүлэгч (ʃ, ɕ), шүргэх гийгүүлэгч (s, z, ʒ, ʒ, x, w), хамрын гийгүүлэгч (m, n, ŋ), чичрэх гийгүүлэгч (r), хажуугийн гийгүүлэгч (l), хагас эгшиг (j) гэж зургаан төрөлд ангилан тодорхойлжээ.

2. Чэн Шы лян “Алтайн тувачуудын хэлний тойм байдал” (“Хэл ба орчуулга” сэтгүүл, 1992 оны 3-р дугаар)-д, тува хэлэнд нийт “p, b, w, m, s, z, t, d, n, r, l, ʃ, ɕ, ʒ, ʒ, k, g, j, ŋ, q, ɕ, x, ʋ” (түүний хэрэглэсэн галигаар тэмдэглэв) зэрэг хорин гурван гийгүүлэгч авиа бий гээд (1992: 23), тэдгээрийг өгүүлэх эрхтний байраар нь хоёр уруулын гийгүүлэгч (p, b, w, m), хэлний үзүүрийн өмнөх гийгүүлэгч (s, z), хэлний үзүүрийн дундах гийгүүлэгч (t, d, n, r, l), хэлний өмнөд этгээдийн гийгүүлэгч (ʃ, ɕ, ʒ, ʒ), хэлний өргөн талын хойгуурх гийгүүлэгч (k, g, j, ŋ),

хүүхэн хэлний гийгүүлэгч (q, c, x, v) зэрэг зургаан төрөлд ангилан, өгүүлэх аргаар нь хамжих гийгүүлэгч (p, b, t, d, k, g, q, c), хамжин шүргэх гийгүүлэгч (ʃ, ɟ), шүргэх гийгүүлэгч (w, s, z, ʃ, ʒ, j, x, v), хамрын гийгүүлэгч (m, n, ŋ), чичрэх гийгүүлэгч (r), хажуугийн гийгүүлэгч (l) гэж зургаан төрөлд ангилж, дууны хөвч чичирхийлэх эсэхээр нь дуугүй гийгүүлэгч (p, s, t, ʃ, ʒ, k, q, x) ба дуутай гийгүүлэгч (b, w, m, z, d, n, r, l, ɟ, ʒ, g, j, ŋ, c, v) гэж хоёр төрөлд ангилан тодорхойлжээ.

3. У Хун вэй “Тува хэлний судлал” (Шанхайн Юань Дун Хэвлэлийн Хороо, 1999 он)-д, тува хэлэнд нийт “b, p, d, t, g, k, ʎ, c, q, ɟ, ʃ, w, j, l, m, n, ŋ, r, z, s, ʃ, ʒ, ɣ” (түүний хэрэглэсэн галигаар тэмдэглэв) зэрэг хорин гурван гийгүүлэгч авиа бий гээд (1999: 14), тэдгээрийг өгүүлэх эрхтний байраар нь хоёр уруулын гийгүүлэгч (b, p, m, w), хэлний үзүүрийн гийгүүлэгч (t, d, n, l, r, s, z), хэлний өмнөд этгээдийн гийгүүлэгч (ɟ, ʃ, ʒ, ʒ), хэлний өргөн талын дундуурх гийгүүлэгч (j), хэлний өргөн талын хойгуурх гийгүүлэгч (k, g, ŋ), хүүхэн хэлний гийгүүлэгч (q, c, ɣ, ʎ) гэж зургаан төрөлд ангилан, өгүүлэх аргаар нь хамжих гийгүүлэгч (b, p, d, t, g, k, c, q), хамжин шүргэх гийгүүлэгч (ɟ, ʃ), шүргэх гийгүүлэгч (w, j, z, s, ʒ, ʃ, ɣ, ɣ), хамрын гийгүүлэгч (m, n, ŋ), чичрэх гийгүүлэгч (r), хажуугийн гийгүүлэгч (l) зэрэг зургаан төрөлд ангилж, дууны хөвч чичирхийлэх эсэхээр нь дуугүй гийгүүлэгч (p, t, k, q, ʃ, s, ʒ, ɣ) ба дуутай гийгүүлэгч (b, d, g, c, ɟ, z, ʒ, ʎ, l, m, n, ŋ, r, j, w) гэж хоёр төрөлд ангилан тодорхойлжээ.

4. Саранхуар “Авианы дуун ухааны зууч тооны хөмрөгт суурилсан Шинжааны тува хэл дэх гийгүүлэгч авианы судлал” (2020) өгүүлэлдээ Шинжааны тува хэлний гийгүүлэгч авианы системд [p^h, b, t^h, d, k^h, g, q^h, c] зэрэг найман хамжих гийгүүлэгч, [ɟ, ʃ^h] зэрэг хоёр хамжин шүргэх гийгүүлэгч, [s, z, ʃ, ʒ, ɣ, w] зэрэг зургаан шүргэх гийгүүлэгч, [n, m, ŋ] зэрэг гурван хамрын гийгүүлэгч, [w, j] зэрэг хоёр ойртох гийгүүлэгч, хажуугийн гийгүүлэгч [l], чичрэх гийгүүлэгч [r] зэрэг нийт хорин гурван гийгүүлэгч бий гэж дурдсан байна (2020: 14).

Хүснэгт 1-2-т Шинжааны тува хэлний гийгүүлэгч авианы тухай судалсан судлаачдын судалгааны дүнгийн харьцууллыг гаргасан болно (үүнд бид гийгүүлэгч авиаг урьдах эрдэмтдийн бүтээлд хэрэглэсэн галигаар нь тэмдэглэв).

26	Г	×	×	×	×
25	У	×	×	×	×
24	Я	×	×	Хүүхэн хэлний	Шүргэх (дуутай)
23	Г	×	×	Хүүхэн хэлний	Хамжих (дуутай)
22	Қ	×	×	Хүүхэн хэлний	Хамжих (дуугүй)
21	Ј	Хэлний өргөн талын	Хатас эгшиг (дуутай)	Хэлний өргөн талын	Шүргэх (дуутай)
20	Х	×	×	×	×
19	Х	Хэлний угийн	шүргэх (дуугүй)	Хүүхэн хэлний	Шүргэх (дуугүй)
18	Ү	Хамрын (дуутай)	Хамрын (дуутай)	Хэлний өргөн талын	Хамрын (дуутай)
17	З	шүргэх (дуутай)	шүргэх (дуутай)	Хэлний өмнөд этгээдийн	Шүргэх (дуутай)
16	Ј	шүргэх (дуугүй)	шүргэх (дуугүй)	Тодорхойлогтгүй	Шүргэх (дуутай)
15	Дз	Хамжин	шүргэх	Хамжин шүргэх	Хамжин шүргэх
14	Ү	Хамжин шүргэх (түрэлттэй ,	Хамжин шүргэх (түрэлттэй ,	Хэлний өмнөд этгээдийн	Хамжин шүргэх
13	І	Хажуугийн (дуутай)	Хажуугийн (дуутай)	Хажуугийн (дуутай)	Хажуугийн (дуутай)
12	Т	Чирэх (дуутай)	Чирэх (дуутай)	Чирэх (дуутай)	Чирэх (дуутай)
11	П	Хамрын (дуутай)	Хамрын (дуутай)	Хэлний үзүүрийн дундах	Хамрын (дуутай)
10	Д	Хамжих (түрэлттүй ,дуутай)	Хамжих (түрэлттүй ,дуутай)	Хамжих (дуунтай)	Хамжих (дуунтай)
9	Т	Хамжих (түрэлттэй, дуугүй)	Хамжих (түрэлттэй, дуугүй)	Хамжих (дуугүй)	Хамжих (дуугүй)
8	Z	Хэлний үзүүрийн өмнөх	шүргэх (дуутай)	Хэлний үзүүрийн өмнөх	Шүргэх (дуутай)
7	S	шүргэх (дуугүй)	шүргэх (дуугүй)	Шүргэх (дуугүй)	Шүргэх (дуугүй)
6	Қ	Хэлний угийн	Хамжих (түрэлттүй ,дуутай)	хойгуурх	Хамжих (дуутай)
5	К	Хамжих (түрэлттэй , дуугүй)	Хамжих (түрэлттэй , дуугүй)	Хэлний өргөн талын	Хамжих (дуутай)
4	W	шүргэх (дуутай)	шүргэх (дуутай)	шүргэх (дуутай)	шүргэх (дуутай)
3	М	Хамрын (дуутай)	Хамрын (дуутай)	Хамрын (дуутай)	Хамрын (дуутай)
2	В	Хоёр уруулын	Хамжих (түрэлттүй ,дуутай)	Хоёр уруулын	Хамжих (дуутай)
1	Р	Хамжих (түрэлттэй, дуугүй)	Хамжих (түрэлттэй, дуугүй)	Хамжих (дуугүй)	Хамжих (дуугүй)
Дугаар	Гийгүүдэгч	Өгүүлэх эрхтэн	Өгүүлэх арга	Өгүүлэх эрхтэн	Өгүүлэх арга
		Сүн Жэн чүнь (20 гийгүүдэгч)		Чэн Шы дян (23) гийгүүдэгч	

26	г	×	×	Хэлний үзүүрийн өмнөх
25	ү	Хүүхэн хэлний	Шүргэх (түрэлтгүй, дуутай)	×
24	я	×	×	Хүүхэн хэлний
23	с	Хүүхэн хэлний	Хамжих (түрэлтгүй, дуутай)	Хүүхэн хэлний
22	ч	Хүүхэн хэлний	Хамжих(түрэлтгүй, дуутгүй)	Хүүхэн хэлний
21	ј	Хэлний өргөн талын дундуурх	Шүргэх (дуутай)	Хэлний өргөн талын дундуурх
20	х	Хүүхэн хэлний	Шүргэх (дуутгүй)	Хүүхэн хэлний
19	х	×	×	×
18	ң		Хамрын (дуутай)	Хэлний үгийн
17	з		Шүргэх (дуутай)	
16	ј		Шүргэх (дуутгүй)	
15	џ	Хэлний өмнөд этгээдийн	Хамжин шүргэх (түрэлтгүй, дуутай)	Хэлний өмнөд этгээдийн
14	џ		Хамжин шүргэх (түрэлтгүй, дуутгүй)	
13	і		Хажуулгийн (дуутай)	Хэлний үзүүрийн дундах
12	г		Чирэх (дуутай)	×
11	п		Хамрын (дуутай)	Хэлний үзүүрийн дундах
10	д	Хэлний үзүүрийн	Хамжих (түрэлтгүй, дуутай)	
9	т		Хамжих (түрэлтгүй, дуутгүй)	Хэлний үзүүрийн өмнөх
8	z		Шүргэх (дуутай)	
7	s		Шүргэх (дуутгүй)	
6	g		Хамжих (түрэлтгүй, дуутай)	Хэлний үгийн
5	k	Хэлний өргөн талын урдлуурх	Хамжих (түрэлтгүй, дуутгүй)	Хэлний үгийн
4	w		Шүргэх (дуутай)	
3	m		Хамрын (дуутай)	
2	b	Хоёр уруулын	Хамжих (түрэлтгүй, дуутай)	Хоёр уруулын
1	p		Хамжих (түрэлтгүй, дуутгүй)	
Дугаар	Гийгүүлэгч	Өгүүлэх эрхтэн	Өгүүлэх арга	Өгүүлэх эрхтэн
		У Хүн вэй (23 гийгүүлэгч)		Саранхуар (23 гийгүүлэгч)

Чиррэх (дуутай)	
	×
Шүрлэх (түрэлтгүй, дуутай)	
Хамжих (түрэлтгүй, дуутай)	
Хамжих (түрэлтэй, дуутай)	
Ойртох гийгүүлэгч (дуутай)	
Шүрлэх (дуутай)	
	×
Хамрын (дуутай)	
Шүрлэх (дуутай)	
Шүрлэх (дуутай)	
Хамжин шүрлэх (түрэлтгүй, дуутай)	
Хамжин шүрлэх (түрэлтэй, дуутай)	
Хажуугийн (дуутай)	
	×
Хэлний угийн	
Хэлний угийн	
Хамжих (түрэлтэй, дуутай)	
Шүрлэх (дуутай)	
Шүрлэх (дуутай)	
Хамжих (түрэлтгүй, дуутай)	
Хамжих (түрэлтэй, дуутай)	
Ойртох гийгүүлэгч (дуутай)	
Хамрын (дуутай)	
Хамжих (түрэлтгүй, дуутай)	
Хамжих (түрэлтэй, дуутай)	
Өгүүлэх арга	

Хүснэгтээс дүгнэхэд:

1. “р, в, m, w” зэрэг гийгүүлэгчийн өгүүлэх арга ба өгүүлэх байрын талаарх эрдэмтдийн тодорхойлолт бүрэн адил байна.
2. “s, z, t, d, n, r, l, ђ, ѓ, ј, з” зэрэг гийгүүлэгчийн талаарх тодорхойлолт ихэнхдээ адил ч зарим гийгүүлэгчийн нарийн ангилал дээр багахан зөрүүтэй байна.
3. “к, г, ђ, х, ђ, ј, q, с, в, ү” зэрэг гийгүүлэгчийн өгүүлэх арга ба байрын тухайд эрдэмтдийн санал дүгнэлт хоорондоо зөрүүтэй, энэ нь Шинжааны тува хэлний гийгүүлэгч авианы судалгаанд өөр өөр үр дүнг авчрах нөхцөл болсон байна.

5. Дүгнэлт

Тува хэлний судалгааны түүхийг хураангуйлан авч үзвэл, Хятадад энэхүү судалгаа харьцангуй орой буюу XX зууны 1950-аад оноос эхэлжээ. Судалгааны анхан шатанд тува хэлний авиа зүй болон үгсийн сангийн зүй голлон судлагдсан бөгөөд мөн харьцуулсан хэл шинжлэлийн чиглэлээр тодорхой тооны бүтээлүүд хэвлэгдсэн байна. Шинжааны тува хэлний авиалбарын тогтолцооны судалгаанд Сүн Жэнчүнь, Чэн Шылян, Чойжинжав, У Хунвэй зэрэг эрдэмтдийн бүтээлүүд онцгой байр суурь эзэлдэг. Эдгээр судлаачид ихэвчлэн “чихээр сонсож, гараар тэмдэглэх” уламжлалт аргыг ашиглан авианы системийг тодорхойлсон нь тухайн үеийн нөхцөлд чухал суурь судалгаа болж, хожуу үеийн тува хэлний авиа зүйн судалгаанд үндсэн эх сурвалж болон ашиглагдаж байна. Иймд тува хэлний авиа зүйн судалгаа цаашид ч судалгааны голлох чиглэл байсаар байх бөгөөд онолын болон хэрэглээний үүднээс цогц, системтэй судалгааг шаардлагатай. Өнөөгийн судалгааны түвшнээс үзвэл, гийгүүлэгч авианы судалгаа хангалттай гүнзгийрч чадаагүй, мөн эрдэмтдийн үзэл санаа нэгдмэл бус, системийн

шинжтэй нэгтгэл хийгдээгүй байна. Тиймээс авиа зүйн судалгааг илүү бүрэн бүтэн, логик уялдаатай тогтолцоонд нэгтгэх шаардлага тулгарчээ. Бусад улс оронд оршин буй Тувачуудын аялгуутай харьцуулахад, Шинжааны тува хэлний авианы судалгаа харьцангуй сул хөгжсөн бөгөөд үүнийг цаашид бүхэллэг, харьцуулсан хүрээнд авч үзэх нь зүйтэй юм. Жишээлбэл, Шинжааны тува хэлний авианы судалгааг Монгол болон Орос Улс дахь тува хэлний судалгаатай уялдуулан, түүхэн хувирлын үүднээс шинжилбэл илүү үр дүнд хүрэх боломжтой. Судалгааг зөвхөн нэг цэгийн түвшинд бус, өргөн хүрээнд, олон улсын туршлага болон орчин үеийн хэл шинжлэлийн онол, арга зүйг хослуулан хийх шаардлагатай байна.

Санхүүжилт: БНХАУ-ын Сурган хүмүүжлийн яамны нийгмийн шинжлэх ухааны суурь судалгааны тэтгэлэгт төсөл болох “Тува хэлний дуун авиа, хоолойн авиа ба хийн урсгалын судлал” (зөвшөөрлийн дугаар: 21ВҮҮ176) ажлын хүрээнд хийж гүйцэтгэв.

Ном зүй

- Бат-Очир,** (2013). *Шинжааны тува хэлний одоогийн хэрэглээний байдлын судлал*. диссертаци, Шинжааны Багшийн Их Сургууль. [Bat-Ochir. *Shinjaany tuva khelnii odoogiin kheregleenii baidlyn sudlal*]. A Study on the Current Usage of the Language Xinjiang Tuvans, dissertation, Xinjiang Normal University. 2013]
- Саранхуар,** (2020). *Авианы дуун ухааны зууч тооны дата хэмрөгт суурилсан Шинжааны тува хэлний гийгүүлэгч авианы судлал*. диссертаци, Баруун Хойтын Үндэстний их сургууль. [Saranhuar. *Aviany duun ukhaany zuuch toony data khömrögt suurilsan Shinjaany tuva khelnii giigüülegch aviany sudlal* [Study on Consonant Phonemes of the Xinjiang Tuvans Language Based on Phonetic Corpus Data, dissertation], Northwest Minzu University. 2020]
- Сүн Жэнчунь,** (2015). 宋正纯. 图瓦语和图瓦人的多语生活北京: 中国社会科学出版社. [Тува хэл ба тувачуудын олон хэлт амьдрал. Бээжин: Хятад Улсын Нийгмийн Шинжлэх Ухааны Хэвлэлийн Хороо. [Song Zheng chun. The Tuva Language and the Multilingual Life of the Tuvans, Beijing: Social Sciences Press of China, 2015]
- У Хунвэй,** (1999). 吴宏伟: 图瓦语, 上海远东出版社. [Тува хэлний судлал. [Wu Hongwei. Studies on the Tuvan Language. Shanghai: Yuan Dong Press, 1999]

Хятад Улсын түрэг төрлийн хэлний тойм байдал, эрдэм шинжилгээний эмхэтгэл. (1983). [Khyatad ulsyn türeg törliin khelnii toim baidal [Turkish Linguistic Society of China. An Overview of Turkic Languages in China, Collected Academic Papers]. 1983]

Хан Рүлинь, (1978). 韩儒林. 唐代都波 (汉版) 社会科学发展战略与路线 杂志. *Тан улсын див*, сэтгүүл өгүүлэл, Нийгмийн шинжлэх ухааны байлдааны шугам. [Han Rulin. Tang Dynasty Div, Journal Article. Line of Social Science Warfare, 3. 1978]

Чэн Шылян, (1992). 程适良. 阿尔泰图瓦人语言概况 [学报], 语言与翻译, Алтайн тувачуудын хэлний тойм байдал. *Хэл ба орчуулга* сэтгүүл. 3. [Cheng Shiliang. An Overview of the Language Altai Tuvans. Journal of Language and Translation, 3. 1992]



Open access: This is an open access article distributed in accordance with the Creative Commons Attribution Non-Commercial (CC BY-NC 4.0) license, which permits others to distribute, remix, build upon this work non-commercially, and license their derivative works on different terms, provided the original work is properly cited, appropriate credit is given, any changes made indicated, and the use is non-commercial. See: <http://creativecommons.org/licenses/by-nc/4.0/>